ШУТДБУХ, АБЯ, ШУА-ийн ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗАР, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ын ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАМТАРСАН ТОГТООЛ

1989 оны 3 дугаар сарын 1 ний өдөр | Дугаар № 40/61/43/12 | Улаанбаатар хот.

"Сурагч" мэдлэгийн төв байгуулах тухай

1. Сурагчдын мэдлэгийг гүнзгийрүүлэн өргөтгөх, сонирхол авьяасыг нь хөгжүүлэх, тэднийг орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололттой танилцуулах, судалгаа шинжилгээний ажлын анхны мэдлэгдэхүүнтэй болгох зорилгоор Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдыг хамран ажиллах "Сурагч" мэдлэгийн төвийг Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэнг түшиглүүлэн 1988-1989 оны хичээлийн жилийн II улиралд багтаан байгуулж ажиллуулахыг СХУХ /н.Дүгэр/, хотын АДЗГ /н.Батмагнай/-т даалгасугай.

2. "Сурагч" мэдлэгийн төвийн тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

3. Улаанбаатар хотын АДЗ /н.Батмагнай/-д <u>Д А А Л Г А Х нь:</u>

а/ "Сурагч" мэдлэгийн төвийн секцүүдэд хичээл заасан багш нарт олгох цагийн хөлсийг СЗАХ-ны хичээл практикийн зардалд жил бүр тусгаж байх.

б/ Мэргэжлийн секцүүдийг удирдсан хүмүүст СнЗ-ийн 1977 оны 310 тоот тогтоолын заалтыг үндэслэн, хичээл заасан цагийн хөлсийг олгож байх.

в/ Жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор "Сурагч" мэдлэгийн төвийн секцүүдэд суралцах сурагчдын тоог тогтоон хичээллүүлж, жи-

лийн эцэст нэгдсэн дүн гаргаж ажиллах.

4. ШУТДБУХ-ны дээд сургуулийн хэлтэс, /Н.Хүрэлдорж/ ШУА-ийн эрдэм шинжилгээний ажлын төлөвлөлтийн хэлтэс /Л.Лхагвасүрэн/ - т даалгах нь:

а/ Их, дээд сургууль, ШУА-ийн хүрээлэнгүүдийн зарим лаборатори, кабинетуудыг түшиглүүлж "Сурагч" мэдлэгийн төвийн секцүүдийг ажиллуулахыг зөвшөөрөх.

б/ "Сурагч" мэдлэгийн төвийн секцүүдийг хариуцах болон лекторид лекц унших хүмүүсийг уг мэдлэгийн төвийн тэргүүлэгчдийн саналаар жил бүр томилж байх.

5. Мэргэжлийн секцүүд ажиллуулахын зэрэгцээ лектори ажиллуулж, жилд 2-оос доошгүй удаа онол-практикийн бага хурал зохион явуулж, сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргадаг уламжлал тогтоон ажиллахыг төвийн тэргүүлэгчдэд даалгасугай.

ШУТДБУХ-НЫ ДАРГА ______________ М.ДАШ

АБЯ-НЫ САЙД
______________ Б.ДАВААСҮРЭН

ШУА-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ
______________ академич Н.СОДНОМ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА
______________ С.МӨНХЖАРГАЛ

ШУТЗБУХ АДЯ
Шинжлэх ухааны академи, Улаанбаатар хотын АДХГЗ-ын тэргүүлэгчдийн 1989 оны ... дугаар сарын ... ны өдрийн хамтарсан ... дугаар тогтоолын I хавсралт.

# "СУРАГЧ" МЭДЛЭГИЙН ТОЛЬНЫ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# Б Ү Р Э Л Д Э Х Ү Ү Н

| | |
|---|---|
| I. Мөнхөр.Д | СХУХ-гийн орлогч захирал /дарга/ |
| 2. Ч.Жагдал | Улаанбаатар хотын АДҮГ-ын СЭАК-ийн эрхлэгч /орлогч дарга/ |
| 3. Б.Пүрэв | СХУХ-гийн арга зүйч /нарийн бичгийн дарга/ |

**Гишүүд:**

| | |
|---|---|
| 4. Г.Содномвааанчиг | СХУХ-гийн секторын эрхлэгч |
| 5. Х.Намсрай | ШУА-ийн физик-техникийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор. |
| 6. С.Батхуяг | БДДИ-ийн хичээлийн эрхлэгч д/э |
| 7. Х.Мөнхбаяр | УБДС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доцент. |
| 8. Н.Түгжсүрэн | ПДС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд эрдэмтэн. |
| 9. Намжилдорж | МУИС-ийн ахлах багш |

оюутан, сурагчдын бүрэлдэхүүнтэй байгуулна. Тэргүүлэгчид нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүн 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна. ШУА-ийн хүрээлэнгийн сектор, лаборатори, их, дээд сургуулийн танхим, лаборатори, салбарын хүрээлэнгүүдийн зураг, төсөл, зохион бүтээх товчоодын материаллаг баазад тулгуурлан секцүүдийг байгуулна. Секц нь ардын уламжлалт зан заншил, соёл, шинжлэх ухаан техник, ахуй үйлчилгээний зэрэг олон төрөл байж болно. Секц нь жил, улирлын хөтөлбөртэй байна. Секцүүдэд авьяас, сонирхолтой сурагчдыг хотын СЗАК-аас эрхлэн элсүүлнэ.

Хичээллэх болон дадлага хийх хугацаа өдөр, цагийг тухайн байгууллага сурагчидтай тохиролцсоны үндсэн дээр тогтооно. Дунд ахлах ангийн сурагчдыг шинжлэх ухааны төрөл бүрийн салбарын ололт амжилттай танилцуулах зорилгоор сар бүтам "лектори" зохион байгуулна.

3. "Сурагч" нийгэмлэгийн төвийн үйл ажиллагаа

а/ "Лектори" зохион байгуулна.

б/ Мэргэжлийн секцүүд байгуулан ажиллуулах, элссэн сурагчдыг лаборатори, зохион бүтээх товчоодод эрдэмтэд, мэргэжилтнийг дагалдуулан ажиллуулж сургалт явуулна.

в/ ЕБС-ийн сурагчдын дунд бүтээлч маргаан, уралдаан зохион олимпиад, уралдаан, тэмцээн явуулах, илтгэл, реферат бичүүлнэ.

г/ Шинжлэх ухааны байгууллага, их, дээд сургууль зохион бүтээх товчоодын тоног төхөөрөмж бүтээгдэхүүн, ШБОС-той танилцах экскурс зохиох зэрэг ажлыг сурагчдын саналын үндсэн дээр зохион байгуулна.

д/ Хичээлийн жилийн эцэст үзэсгэлэн байгуулах, онол-практикийн бага хурал явуулах ШБОС, тоног төхөөрөмжийн загвар гаргах

[illegible]
Шинжлэх ухааны академи, Улаанбаатар хотын АДХГЗ-ны тэргүүлэгчдийн 1989 оны ... дугаар сарын ... ний өдрийн хамтарсан ... дугаар тогтоолын II хавсралт.

# "СУРАГЧ" МЭДЛЭГИЙН ТӨВ БАЙГУУЛАХ ЖУРАМ

## 1. "Сурагч" мэдлэгийн төвийн зорилго:

ЕБС-ийн сурагчдыг шинжлэх ухааны төрөл бүрийн салбаруудын ололт амжилттай танилцуулах, судалгаа шинжилгээний ажлын анхны мэдлэгдэхүүнтэй болгох, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, бүтээлч авьяас билгийг нь хөгжүүлэх, чөлөөт цагаа үр бүтээлтэй ашиглах боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Сурагч" мэдлэгийн төвийг Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэнг түшиглэн байгуулна.

"Сурагч" мэдлэгийн төв нь:

а/ Сурагчид өөрсдийн сонирхож байгаа шинжлэх ухааны салбарын аль нэг чиглэлээр онол практикийн мэдлэгээ гүнзгийрүүлэн хөгжүүлэх.

б/ Өөрийн бүтээлч үйл ажиллагаа, хичээл, сургууль, амьдралаас олж авсан мэдлэгээ практик дээр туршиж өөрийгөө хөгжүүлэхэд нь туслана.

## 2. "Сурагч" мэдлэгийн төвийн удирдлага, зохион байгуулалт.

"Сурагч" мэдлэгийн төвийн үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр байгуулагдсан тэргүүлэгчид удирдан зохион байгуулна. Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд ШУА, СХУХ, БМДИ-ийн эрдэмтэд, э/ш-ний ажилтан, заах аргачид, их дээд, ерөнхий боловсролын сургуулийн багш,

хамгаалуулах зэрэг хэлбэрээр ажлаа дүгнэнэ.

<u>4. Төсөв санхүү:</u>

"Сурагч" мэдлэгийн төвд шаардлагатай зардлыг хотын АДХГЗ, төсөвтөө тусган улирал тутам "сурагч" мэдлэгийн төвийн тэргүүлэгчдийн тооцоогоор шилжүүлж байна.

Түшиглэсэн газрууд сурагчдыг ажиллуулахад шаардагдах зардлыг жил бүрийнхээ төсөвт тусгаж байна.